



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/154

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалаар баталсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Баян-Уул сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Ш.Насан	(Жангар музейн дарга)
Гишүүд	Ү.Баттулга	(иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн)
	Г.Түмэнжаргал	(Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсон))
Нарийн бичиг:	М.Батсайхан	(Есөнбулаг сумын иргэн)
	Б.Эрхбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Ш Насан)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

